



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан)¹

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ БАТАЛГААГ ЗӨВХӨН ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, ЧАДАХУЙН /МЕРИТ/ ЗАРЧМЫН ДАГУУ ТОМИЛОГДСОН АЛБАН ХААГЧ ЭДЭЛНЭ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/0047

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч нь Х аймгийн А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн тоот тогтоолоор А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон байна. Улмаар нэхэмжлэгчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн тул А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн тоот захирамжаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 23,814,400 төгрөгийг нэхэмжлэгчид олгожээ.

Гэтэл хариуцагч болох Х аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын улсын ахлах байцаагчаас нэхэмжлэгчийг төрийн ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшлийн шаардлага хангаагүй, хууль бусаар томилогдсон тул төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг үндэслэлгүй олгосон гэж үзэн нэхэмжлэгчээр буцаан төлүүлэхийг А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулж, төлбөрийн акт тогтоосон байна. Нэхэмжлэгчээс уг актыг эс зөвшөөрч Сангийн яаманд гомдол гаргасан боловч Сангийн сайдын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн тоот албан бичгээр төлбөрийн акт тогтоосон нь үндэслэлтэй гэх хариуг өгчээ.

Иймд нэхэмжлэгчийн зүгээс Х аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын улсын ахлах байцаагчийн 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн тоот төлбөрийн актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс** “Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 1 дүгээр

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/3502?id=3&court_cat=3



зүйлийн 1.1², 5 дугаар зүйлийн 5.2³-т тус тус заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албан хаагч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрхтэй бөгөөд тухайн нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрхтэй төрийн албан хаагч нь Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг нягтлах үүрэгтэй. Гэтэл төрийн жинхэнэ албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалд нэхэмжлэгчийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 43 дугаар зүйлийн 43.3.2, 43.4, 43.6-д заасныг зөрчиж томилсныг Х аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн тоот зөвлөмжөөр тогтоосон тул уг эрхийг эдлүүлсэн нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1⁴-д нийцэхгүй” гэж дүгнэн, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

2. **Давж заалдах шатны шүүхээс** “Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолд зааснаар хамгийн багадаа 5 жил, түүнээс дээш жил ажилласан төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг авах эрхтэй байна. А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас хурлын нарийн бичгийн даргын ажлын байранд 2022 онд нэг удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд нэг удаа сонгон шалгаруулалт зарлахад тухайн ажлын байранд шалгарсан хүн байгаагүй тул нэхэмжлэгч нь түр орлон гүйцэтгэгчээр үргэлжлүүлэн ажилласаар ирсэн бөгөөд томилогдохдоо хууль зөрчсөн гэхээс илүүтэй, томилогдох үеийн нөхцөл байдал, төрийн албаны шалгалтад тэнцсэн нөөцөд байгаа нэр дэвшигч байсан эсэх зэрэг тухайн сумын бодит нөхцөлийг харгалзан үзэх ёстой. Энэ тохиолдолд түүнд нэг удаагийн тусламж, дэмжлэг олгохгүй гэх агуулгаар журмыг тайлбарлаж байгаа нь хуулийн зорилгод нийцээгүй, бодит нөхцөлд тохироогүй байна” гэж дүгнэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.
3. **Хариуцагчийн зүгээс** “Нэхэмжлэгч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага шалгуурыг хангаагүй, хууль бус томилгоотой талаарх Х аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн албан бичиг, тухайн иргэнийг ажилд томилсон тушаал зэргийг үндэслэн Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолын хавсралт дахь “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай” журмын 5.2-т заасныг ажил олгогч нь хянаж үзэлгүй нэхэмжлэгчид давуу байдал олгож тэтгэмж олгосон гэж үзэж нөхөн төлүүлэх төлбөрийн актыг тогтоосон. Уг журам нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд энэ журмын

² Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 1 дүгээр зүйлийн 1.1 “Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөнө”.

³ Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол, Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 5 дугаар зүйлийн 5.2 “Төрийн албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг хянаж үзсэний үндсэн дээр төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэнэ”.

⁴ Төрийн албаны тухай хууль (2017)-ийн 60 дугаар зүйлийн 60.1 “Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”.



дагуу хуулийн шаардлага хангасан, албан хаагчдад тухайн буцалтгүй тусламж олгогдож ирсэн байдаг. Гэтэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 02 дугаар сарын 04-ний 100 дугаар магадлалын хянавал хэсэг, тогтоох хэсэгт нэхэмжлэгчийг төрийн жинхэнэ албан хаагч байсан мэтээр дүгнэж хуулийн зохицуулалтыг хэрэглэсэн” гэх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ.

4. **Хяналтын шатны шүүхээс:** Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.5 болон Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д заасан зохицуулалт нь тухайн төрийн албан тушаалыг эрхлэх болзол шаардлагыг хангасан бөгөөд чадахуйн зарчмын дагуу төрийн албанд томилогдсон этгээд нь төрийн албан хаагчид хуулиар тусгайлан тогтоосон хөнгөлөлт, бусад тэтгэмж, тусламжийг авах эрхтэй байх, харин хүчин төгөлдөр хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, үүний улмаас тухайн албан тушаалд нэр дэвших эрхийг хуулийн дагуу олж аваагүй, болзол шаардлага хангаагүй атлаа төрийн албанд томилогдсон этгээд “төрийн албан хаагчийн баталгаа”-г эдлэхгүй байх агуулгатай гэж үзнэ. (13)⁵
5. Хэрэгт авагдсан Х аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн тоот зөвлөмж болон 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн тоот албан бичиг, талуудын шүүхэд гаргасан тайлбар, бусад баримтаар томилох эрх бүхий этгээд нь төрийн албаны сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлэхтэй холбоотой хуульд заасан журмыг зөрчиж, түүнийг А сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилсон”, “... /уг/ ажлын байранд 2022, 2023, 2024 онд нийт 4 удаа сонгон шалгаруулалт зарласан боловч нэхэмжлэгч нэр дэвшээгүй”, “мөн төрийн албаны шалгалт өгөөгүй байсан тул уг албан тушаалд түүнийг жинхлэн томилогдох боломжгүй байсан” зэрэг үйл баримт тогтоогджээ. (14)
6. Дээрх журмын дагуу хариуцагч нь “төрийн албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг хянаж үзсэний үндсэн дээр төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэх” үүрэгтэй, энэ тохиолдолд төрийн албанд хууль тогтоомжийн дагуу томилогдоогүй нэхэмжлэгчид өндөр насны тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон нь хууль бус, энэ үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна. (15)
7. Харин давж заалдах шатны шүүх Төрийн албаны тухай хуулийн холбогдох зохицуулалтын зорилго, агуулгыг маргааны үйл баримтад холбогдуулан буруу тайлбарлаж, хэм хэмжээний актаар тусгайлан зохицуулсан харилцаанд Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 5.2 дахь заалтыг хэрэглэлгүй, “түр орлон гүйцэтгэгчээр томилохдоо хууль зөрчсөн гэхээс илүүтэй тухайн үеийн бодит нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой, удаа дараа сонгон шалгаруулалт явуулсан боловч хүн томилогдоогүйгээс түр орлон гүйцэтгэгчээр үргэлжлүүлэн ажилласан энэ тохиолдолд түүнд нэг удаагийн тусламж, дэмжлэг олгохгүй гэж журмыг тайлбарлах нь хуулийн зорилго

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



болон бодит нөхцөл байдалд нийцэхгүй” гэж дүгнэсэн нь буруу, магадлал үндэслэл бүхий болоогүй байна. (16)

8. Дээрх үндэслэлээр хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэжээ.

---o0o---